

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”
Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234740

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-ҮҮР СУМЫН БУРИАДУУДЫН
ХЭЛ¹-НИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖЛЭЛ²

С.Батхишиг³

Түлхүүр үг: Монгол хэл аялгуунуудын ангилал, Хөвсгөлийн Буриаддууд, халхажсан Буриад, хэлний хувьсал өөрчлөл, мөхөж буй хэл

Оршил. Хэл шинжлэлчид хэлний тогтолцоо, өөрчлөлт, хэрэглээ гэх мэтийг олон талаас нь судлахаас гадна хэлний баримт хэрэглэгдэхүүн, түүгээр дамжуулах мэдээлэл, сурвалж зэргийг хадгалах, хамгаалахад зохих үүрэгтэй. Үүнд,

Хэл, аялгууг хамгаалах олон улсын байгууллагуудын зорилтын хүрээнд:

- Монгол улс дахь болон монгол хэлний нутгийн аялгуудын бодит нөхцөлийг тодорхойлох, баримтжуулах, тодорхойлох ажлыг хийх.

- Цөөхөн байгаа хэлний өв тээгчдийн хажууд илүү урт хугацаагаар сууж хууч яриа, түүх зэргийг баримтжуулах.

- Ахуй соёлын холбогдолтой үгийн сан зэргийг ажиглаж, цуглуулж, баримтжуулах.

Хэл, соёлын бодлогын хүрээнд:

- Угсаатны соёл, хэлийг судлах, таниулах ажлыг дэмжүүлэх

- Угсаатан болон тэдний соёл, хэлний атласыг жил бүр шинэчлэн олон улсын байгууллагын бүртгэлд мэдээллийг танилцуулж байх.

Бодит ахуй орчинд нь бүх төрлийн бичлэгийг хийж баримтжуулах нь магадгүй хожим тухайн угсаатны хэл, соёлын зүйлийг виртуал орчинд ч юм

¹ Энэ судалгааны үр дүнгээр Хөвсгөлийн буриадын хэлийг “буриад нутгийн аялгуу” гэж дүгнээгүй учир “нутгийн аялгуу” гэсэнгүй. Мөн нийгэм, түүхийн асуудлыг хэлний өөрчлөлт хувьсал, уусалтай холбон авч үзэж байгаа асуудал тул “буриад угсаатан”, ЮНЕСКО-гийн тодорхойлолтын хүрээнд “хэл” гэх нэр томъёог өгүүлэлд хэрэглэлээ.

² Энэхүү өгүүллийг МУИС (P2020-3951)-ийн дотоод төслийн хүрээнд бичив. Төслийн хээрийн судалгааны үр дүнг анх “Монгол угсаатнуудын хэл аялгуу, бичиг соёлын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага”, МУБИС, 2023 олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн бөгөөд тэрхүү илтгэлийг нэмэн дэлгэрүүллээ.

³ Өгүүллийг уншиж, үнэтэй санал шүүмж бичсэн “Монгол судлал” сэтгүүлийн редакцийн зөвлөлд талархал илэрхийлэе. Энэ өгүүлэлд академик ёс зүйн аливаа асуудал гарвал зохиогч хариуцна.

уу сэргээж болох боломжтой гэж үзэж хэл, соёлын баримтжуулалтыг уусаж буй хэл, аялгууны гол арга зүй гэж үзэх хандлагатай болжээ. Нөгөө талаас ахуй соёл, үзэл санааны хувьд хүчирхэг байсан угсаатан мөхсөн ч соёлын элементээ үлдээсэн байх нь дэлхийн түүхэнд элбэг байдаг. Үүний нэг жишээ бол Хөвсгөлийн буриадын хэл ууссан ч тэдний ахуй соёлын орчин тэндэхийн буриадаас халхчуудад хүртэл уламжилжээ. Ахуй соёлын элементийг дагаад түүнд холбогдон нэрлэх үгийн сан ч үлдэж хоцорсон байна.

Нутгийн аялгууны ангилалд газар зүйн байршлаас илүү нийгмийн нөхцөл байдал нутгийн аялгуунд нөлөөлж хөгжиж ирснийг анхаарууштай. “Нутгийн аялгуу судлал” (dialectology) нь ардын зан заншлын судлал, ардын аман зохиол судлал зэрэгтэй холбогдож тэдгээрийн авиа зүй, үг зүй, үгийн сангийн онцлогийг авч үздэг бол бүс нутгийн аялгуу судлал (regional dialect) нь тухайн хэл аялгуугаар ярилцагчийн нийгмийн байдалтай нь мэдэрч судлахад төвлөрч байна.

Монгол Улс дахь нутгийн аялгууны хээрийн шинжилгээний ажил 1955-1970-аад онд эрчимжиж, түүнд тулгуурласан нутгийн аялгуу, аман аялгууны ангилал судалгааны бүтээлүүдэд нийтлэгдсэн байдаг. Тэдгээр судалгааны ажилтай танилцаж байхад зарим аман аялгууны тодорхой баримт хэрэглэгдэхүүн ховор ч угсаатны гарал байдлыг үндэслэн буриад, ойрад, халх аялгууны аль нэг бүлэгт ангилсан нь бий. Энэ нь тухайн ангиллыг хийх цаг үедээ тодорхой хэмжээгээр бодитой үр дүн байсан байх нь дамжиггүй юм. Гэвч хэл бол нийгэм, түүх, улс төрийн нөхцөл байдлыг даган өөрчлөгдөж болдог. Тиймээс харьцангуй мэдээ баримт ховортой зарим тодорхой аман аялгууг сурвалжлах, хэлний бодит байдлыг дүгнэх, нутгийн аялгууны ангилалд аль хэсэгт багтахыг тодруулах зорилгоор Хөвсгөлийн буриадын аялгууг сонгон судалсан юм.

Судлагдсан байдал. Өмнөх судалгааны ном зохиолд Хөвсгөлийн Буриадын хэлийг бараг бүгд “буриад аялгууны ангилал”-д багтаан авч үзжээ. Тухайлбал, БНМАУ-ын ШУА-аас зохион байгуулсан аялгуу судлалын хээрийн шинжилгээний ангийн өргөн хүрээтэй ажлын дотор буриад аялгууг судалсан судалгааны үр дүн бий.

1956 онд Э.Вандуй ахлагчтай анги Хэнтий, Дорнод аймгийн Хөлөнбуйр, Гурванзагал, Чойбалсан суманд оршин суух барга, Хөвсгөл аймгийн Чандмань, Цагаан-Үүр суманд хэсэг бусгаар суух барга (МХСТ, 2020: 63) аялгууг судалжээ.

Ж.Цолоо 1976, 1998 онуудад хээрийн судалгаа хийсэн байдаг. Үүндээ, Монгол улсын Дорнод, Хэнтий, Сэлэнгэ, Хөвсгөл, Булган аймагт буриад монголчууд нутагладаг гээд “Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумын түнхин, санагын буриад” (Цолоо, 2011: 247-248) гэж тэмдэглэсэн байна.

Г.Батзаяа нар (2022)-д мөн өмнөх судалгаануудад дурдсан ангилалд тулгуурлан Сэлэнгэ-Үүр голын буриад аман аялгууг:

2.1. Цонгоолын салбар аман аялгуу: Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Шаамар, Дулаанхаан, Жавхлант, Хүдэр, Ерөө сумынхан болон Хэнтий аймгийн Батширээт, Биндэр сумын цөөнх.

2.2. Түнхэн санагын салбар аман аялгуу: Хөвсгөл аймгийн Ханх, Цагаан-Үүр, Булган аймгийн Тэшиг сумын цөөнх.

2.3. Ашабагад буриадын салбар аман аялгуу: Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын цөөнх (Батзаяа нар, 2022: 25) хэмээн буриад аялгууны ангилалд багтаасан байна.

Судалгааны асуулт. Дээр дурдсан судалгааны бүтээлүүдэд Хөвсгөлийн буриад угсаатны хэлийг буриад аялгууны ангилалд багтаан оруулсан боловч “буриад аялгуу”-ны жишээ баримт яагаад тусгайлан дурдаагүй вэ? Мөн Сэлэнгэ-Үүр гол орчмын буриадууд гэж яагаад ерөнхийлөн нэрлэж багтаасан бэ? гэдэг асуудал бол энэхүү хээрийн судалгааны анхдагч асуулт байлаа.

Хоёрдугаарт, Хөвсгөлийн буриад угсаатны “хэл” нь үнэхээр буриад аялгууны салбар уу?, халх аялгууны салбар болж хувьссан уу?, өөрөөр хэлбэл, Хөвсгөлийн буриадын аялгуу нь нийгэм-түүхийн шалтгаанаар халх аялгуундаа ууссан уу? гэсэн асуултад дүн шинжилгээ хийж, дүгнэлтэд хүрэх нь гол асуудал болсон юм.

Судалгааны арга зүй. Манай судалгааны баг 2021 оны 8 сар, 2022 оны 1, 2 сард Хөвсгөлийн Цагаан-Үүр, Чандмань-Өндөр суманд хээрийн судалгаа хийсэн юм. Хөвсгөлийн буриад угсаатны дунд хэл, соёлын бодит байдлыг үнэлэх, уусаж байгаа хэл аялгууг баримтжуулах⁴ (Documenting Endangered Languages = DEL) олон улсын байгууллагын арга зүйг хэрэглэв. Үүнд, хэл-соёлын баримт-хэрэглэгдэхүүнийг дуу болон дүрс бичлэг болгон хурааж авах, архивлах, түүнийг задлан шинжилж хэл аялгууны нөхцөл байдлыг үнэлэх зэрэг багтана.

Судалгааны хүрээ. Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сум нь буриад угсаатан олонх боловч буриад аялгуугаар хэлэлцэгчийг олоход тийм амар байсангүй. Өдөр тутмын амьдрал нь халх аялгуугаар өрнөх тул нэлээд сурвалжилж байж дараах настуудтай уулзсан билээ. Түүний үр дүнд урт яриа өрнүүлж, тэдний сэргээн санан дурсах хууч яриа, дуу зэргийг дүрсжүүлэн авсан юм. Тиймээс яг тодорхой “энэ цагт” тэднийг уусаж буй буриад аялгуугаа тээж яваа хэлний өв тээгчид гэж тодорхойлж болно.

1. Ц.Маруш, 81 настай, эмэгтэй, гэр бүлийн хүн нь мөн буриад угсаатан байжээ.

2. Б.Өлзийбаатар, 75 настай, эрэгтэй, гэр бүлийн хүн нь Ц.Баяндалай, буриад хүн.

3. Ц.Баяндалай, 72 настай, эмэгтэй, гэр бүлийн хүн нь Б.Өлзийбаатар, буриад хүн.

4. Ч.Нямсүрэн, 76, эмэгтэй, халх айлд өргөгдсөн буриад угсаатан.

5. Л.Галбаабадраа, 78, эрэгтэй, буриад угсаатны түүх, тэдний дууг сэргээх, өвлүүлэх ажлыг хийдэг номын хүн.

Жич : Чандмань-Өндөр сумаас буриадаар хэлэлцэгчийг олоогүй.

⁴ Дэлхий даяар цөөнхийн хэл нь бүс нутаг, бусад үндэстэн-угсаатны хэлний дарамтад өртөж байсан түүхтэй. Хэл судлаачид эдгээр хэлийг хамгаалах арга замыг боловсруулж, “хэлний баримтжуулалт”, эсвэл “баримтат хэл шинжлэл” гэж нэрлэх болжээ. 1995 оноос энэ шинэ хандлага бий болсон бөгөөд өдөр тутмын ярианаас эхлээд өгүүлэмж, мөн залбирал, ёслол, уншлага зэрэг зан үйлд холбогдох дуу дүрсний дээжийг бий болгодог. Энэ нь тухайн хэлийг нийгэм-соёлын нөхцөлд нь судалж, жишээ баримттай “корпус”-ыг бий болгох зорилготой юм. Өөрөөр хэлбэл, эх хэлний боловсрол, түүний нийгмийн байр суурийг нэмэгдүүлэх, мөн тухайн хэл, аялгууг дахин сурах, сэргээх, хэлний нөхцөлийг үнэлэх зорилгоор орчин үеийн технологийн тусламжтайгаар архивлаж байна. Тиймээс өндөр чанартай аудио, видео бичлэг хийх нь чухал. Тухайн хэлийг судлах, бичих, ашиглахдаа зөвшөөрөл авч, судалгааны ёс зүйг баримталдаг (Austin, 2021: 199-211).

Тэдний түүх. Энэхүү судалгаа бол хэл–нийгэм, улс төрийн асуудлыг даган хэрхэн өөрчлөгдсөнийг буюу халхажсаныг Хөвсгөлийн буриад⁵-ын жишээгээр судалсан ажил тул тэдний түүхийг товч танилцуулъя.

Соёны нуруу, Бүрэнхаан уулын хавиар аж төрөх Түнхэн, Захаамин аймгийн нутгаас нүүдэллэн ирсэн Буриадууд нь угтаа Эхирэд, Хонгоодор овогтон ажээ. 1689 онд Оросын Головын Нерчугийн гэрээгээр Байгал далай хавиар нутаглаж байсан буриад монголчуудыг Оросын харьяанд нэгтгэсэн байна. Ханх, Түнхэний буриадууд 1727 онд Манж-Оросын хилийн гэрээний дараа хоёр хуваагдан суух болов. Ханхын буриадууд Богд хаант Монгол улсын үед Хөвсгөлийн Урианхай хошууны арын хоёр хошуунд харьяалагдан суурьшиж, Монгол оронд ангийн үслэг нийлүүлэх ажил эрхэлж байжээ. Энэ албанд буриад гэр бүл 317 байснаас эрэгтэй 737, эмэгтэй 791, нийт 1528 хүн амтай байсан байна. 1922 оны долдугаар сард Улз, Онон, Хэрлэн, Тэшиг, Ноён уул, Ерөө гол, Ханхын буриадууд нийт 927 өрх 3656 буриад иргэн Монгол улсын харьяат болжээ.



Дашрамд тэмдэглэхэд, монгол угсаатны түүхийн холбогдолтой асуудлыг судлахад ургийн бичиг, ургийн баярт зориулсан ном товхимол хэвлэж, хууч яриа зэргийг сэргээн тэмдэглэх болсон нь ач холбогдолтой ажээ.

⁵ Монгол улсын Хэнтий, Дорнод Сэлэнгэ, Хөвсгөл, Булган зэрэг аймгийн зарим сумдад буриадууд суухаас гадна БНХАУ, ОХУ-д харьяалагдах болсон буриад угсаатан бий. Тэд бүгд хэл аялгууны зэрэглэлээр өөр өөр статустай болжээ. Тухайлбал, БНХАУ дахь буриадуудыг нутгийн аялгууны ном зохиолд зүүн хойд аман аялгуу ч гэдэг бөгөөд Хөлөнбуйр хотын Шинэ барга баруун хошуу, Шинэ барга зүүн хошуу, Хуучин барга хошуу болон Эвенк үндэстний өөртөө засах хошуу, Хайлаар зэрэг газарт суурьшжээ. Түүхэн тэмдэглэлийг үндэслэвэл, баргачууд нь нийтийн он тооллын 11-р зууны сүүлчээр Байгал нуурын орчим Баргужин төхөмөөр нутаглаж байснаас өмнө урьд хожид Хөлөнбуйрт нүүж ирсэн байжээ. Ингээд өмнө ирсэн баргачуудыг нь хуучин барга, сүүлд ирснийг нь шинэ барга гэжээ. Барга гэдэг нэрийг “Монголын нууц товчоо”-д гардаг “Баргужин”, “Баргудай” зэрэг үгтэй холбоотой гэж үздэг. “Буриад” гэдэг нэр нь Байгаль нуур орчим амьдарч байсан Барга баатар Буриад, Хоридай гэдэг 2 хөвүүнтэй гэсэн домог ярианаас уламжлалтай гэж ярилцдаг. Буриадчууд нэлээд хожуу Байгал нуур хавиас нүүж иржээ. Монгол хэлний нутгийн аялуунууд дотор хүн ам хамгийн цөөн.



Зураг 1. Санага болон Түнхэний буриад гэр бүлийн ургийн бичгийг багтаасан түүх бичлэг

Газар нутгийн онцлог. Цагаан-Үүр сум нь Эрдэнэбулган, Чандмань-Өндөр, Ханх сумдтай хаяалж, ОХУ-ын Буриадын Түнхэн, Захааминтай хил залгадаг. Цагаан-Үүр сумыг Үүрийн голын баруун талаар суурьшуулж, 1931 онд байгуулжээ.



Зураг 2. Буриад нэрийг монгол төвд нэрээр солих, газар нутаг заалгах зэргээр тэдний түүх адил өгүүлэмжтэй.

Угсаатны бүрэлдэхүүн, амьдралын хэв маяг. Цагаан-Үүр сумын хүн амыг буриад, халх, урианхайчууд бүрдүүлнэ. Нутгийн уугуул иргэд урианхайчууд байсан бөгөөд хожим хойд хилийн манаанд халх иргэдийг дайчлан ирүүлж суурьшуулжээ. Амьдрах хэв маяг, ёс заншилд буриад болон Оросын нөлөө их үлдсэн нь орос маягийн улаан дүнзэн байшин, буриад талх, цөцгий, арьс элдэх эргүүлэг зэргээс харагдана. Буриад угсаатныг нь Санага, Түнхэн буриадууд бүрдүүлэх ба Санага, Түнхэн нь газрын нэр юм. Хөвсгөл аймгийн Эг, Үүр голын хавиар нутагладаг. Одоогийн хүн ам нь 2415 байгаагаас хоорондоо гэрлэсэн буриад гэр бүл 26 байна гэсэн бүртгэл бий. Бусад буриад иргэд халх юм уу, урианхайчуудтай гэрлэжээ.



Зураг 3. Хөвсгөлийн Цагаан-Үүрийн буриад айлын ахуйгаас

Буриад аялгуугаа хэрэглэж байгаа нь. Ердийн амьдралын хэл яриа нь халхажсан тул тэдний өдөр тутмын ярианаас буриад аялгууных нь үг хэллэг, авиа зүй, үг зүйн онцлогийг олж сонсох хялбар биш болжээ. Үүнд, улс төрийн түүхээс шалтгаалсан хаалттай нийгэм голлон нөлөөлсөн байлаа. Ер нь, бараг хилийн наана Монгол улсын Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Сар тохойд нутагласнаас нааш халхажиж иржээ. Маш цөөхөн хүн гэр бүлийн хүрээнд уугуул буриад аялгуугаа хэрэглэж байсан байх боломжтой нь тэдний амьдралын түүхээс тодруулж болно. Тухайлбал, Ц.Маруш гуай бол Санагын буриад бөгөөд кирилл бичиг үсэгт төдий боловсроогүй учир халхжих нь нийгмийн хүрээллээс л шалтгаалжээ. Мөн түүний гэрийн хүн нь буриад хүн байсан учир хууч яриа, дуу, өдөр тутмын яриандаа ч буриад аялгууны элементийг бусдаасаа илүү хадгалан авч үлдсэн байлаа.



Зураг 4. Ц.Маруш гуайтай түүний гэрт. Буриад дээлээ сүүлд хийлгэж, цагаан сар, Алтаргана наадам зэрэгт оролцохдоо өмсөх болжээ.



Зураг 5. Түнхэний буриад Б.Өлзийбаатар, Санагын буриад Ц.Баяндалай нарын гэр бүл

Түнхэний буриад Б.Өлзийбаатар, Санагын буриад Ц.Баяндалай нар гэр бүл бөгөөд хоорондоо буриадаар ярилцах нь ховор ч зарим үг, нөхцөлийг хэрэглэж,

дуу зэргийг дурсан санаж байлаа. Мөн Ц.Баяндалай гуайн ээж нь Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Хатгалын сургуулиудыг талхаар хангадаг буриад талхны соёлыг үүсгэсэн хүн бөгөөд аав нь морин чаргаар тээвэрлэж тараадаг байжээ. Тиймээс талх барих, будаа тариалах, хураах зэрэгтэй хамаатай олон дурсамж ярьж, түүндээ ахуйн олон сайхан буриад үгийг хэлж байв.



Зураг 6. Л.Галбаабадраа гуайн гэрт

Тэрбээр хэдийгээр халхаар ярих боловч олон дууг буриад аялгуугаар бичиж хэвлэн, мөн өөрөө ч дуулж өгсөн юм.

Харин Ч.Нямсүрэн гуай бол халх айлд өргүүлсэн буриад охин. Мөн л хэл аялгууны хувьд бүрэн халхажсан боловч тэрээр дурсамж, түүхээ хадгалан үлджээ.



Зураг 7. Ч.Нямсүрэн гуайтай, Дээрхийн хийд, 2022 оны цагаан сарын үеэр

Хэлний өвөө хадгалан тээгчдийн дурсамж, дуу зэргээс буриад үг, хэллэг хайх нь

Энэхүү судалгаанд хамрагдсан хэлний өв тээгчдийн олон цагийн бичлэгээс дараах буриад аялгууны авиа үг зүйн онцлог, үгийн санг тодорхойлж болно. Гол төлөв буриад аялгууны нийтлэг авиа зүй, үг зүйн үзэгдлийг тэд заримдаа хэлдэг. Жишээ нь,

1. ч-г ш-ээр, с-ийг ш-ээр, с-ийг х-ээр дуудах гэх мэт авианы үзэгдэл :

буриад	халх
явшхав [jawʃχaw]	явчхав
ямарш байв [jamarʃ bæw]	ямар ч болов
ошхов [ɔʃχɔw]	очив
шөтгөр [ʃɔtχɔr]	чөтгөр
нэгш [negʃ]	нэг ч
авхашгүй [awχaʃgui]	авах ч үгүй
хавшуу [χawʃo:]	хавчуу
ошхом [ɔʃχɔm]	очиход
яхшым [jaχʃi:m]	ях гэсэн юм
хайхан [hæ:χaŋ]	сайхан
хузиг [χʊzik]	хутга
олон улад [ɔlɔn olad]	олон улс.

Буриад аялгуу нь угтаа а /a/, э /ə/, и /i/, о /ɔ/, у /ʊ/, ү /u/ гэсэн үндсэн зургаан богино эгшигтэй. Гэтэл Хөвсгөлийн буриадуудын хэл нь халхажсан учир ө-г ү-гээр биш, халх шиг ө-гөөр хэлдэг болжээ.

2. Өнгөрсөн цагийн нөхцөл, биед хамаатуулах төгсгөл бүхий хэл зүйн үзэгдэл:

буриад	халх
яваа [jawa:]	явсан
үлдээ [ulde:]	үлджээ
сүй тавиа [sui tæwa:]	сүй тавьсан гэнэ
дугараа [dogara:]	дугарсан
унтыш [ontʰi:ʃ]	чи унт
хэвтийт [xɛftʰi:tʰ]	та хэвт
өгөхгүйв [ɔgɔxguiw]	өгөхгүй би
даархат [da:rχatʰ]	даарна чи
идэхтий [idexti:]	та идээрэй.

Түрэг төрлийн хэл, ойрад аялгуу шиг үйл үгийн биед хамаатуулах хэлбэрийг 1, 2-р бие маш тодорхой утгаар хэрэглэх боловч маш цөөхөн жишээг л дурдаж болно. Харин үйл үгийн өнгөрсөн цагийн -а: / -е: / -э: / -о:-г судалгаанд оролцсон хоёр эмэгтэй бараг ерийн яриандаа ч хэрэглэж байлаа.

tʰend ɔʃxɔt ɔlɔn χuŋ baiga:
тэнд очиход олон хүн байсан
tʰere tʰa:wai mant xeldʒ uge:
тэр өвгөн надад хэлж өгсөн

3. Бичгийн хэлний онцлог бүхий үг, нөхцөл

буриад

дээл [degel]

хөшгийн хойно [xəʃigi:ŋ xœ:nɔ]

хоолойн эм [xɔ:lœ:ŋ em]

хүнийн [xuni:ŋ]

халх

дээл

хөшигний цаана, ард

хоолойны эм

хүний.

4. Ураг садны зарим үг хэллэг :

буриад

баавай [ba:wæ:]

эвий [ewi:]

авгамнай [awgamnæ:]

хамган [hamgan]

таавай [tʰa:wæ:]

халх

өөрийн аав

өөрийн ээж

авга талынхан

эхнэр, авгай

хөгшин аав, өвөө, настан (ач гучаа

үзээгүй бол 100 ч хүрсэн “таавай”

нэрийг авахгүй, хүндэтгэлийн утгатай байна)

хөгшин ээж, эмээ

хүргэн ах, дүү

бэр, бэргэд

охин

манай

тээвээ [tʰe:we:]

хурайх [xoræ:χ]

эзий [ezi:]

басган [basgan]

мань [mæn]

5. Нийгэм, түүхэн үг хэллэг:

буриад

улаан цагаан [ola:ŋ tsaga:ŋ]

тахир ногоон [tʰaxir nɔgɔ:ŋ]

тараа барах [tʰara: barax]

халх

үймээн самуун (хэлмэгдүүлэлтийн

үед гарсан үймээн самууныг

ийн ярилцах ажээ)

шорон (хэлмэгдүүлэлтийн үед

буриадуудыг хорьж байсан газар)

хүчээ барах, эцэх (хэлмэгдүүлэлтийн

үед ядарч туйлдаж байсныг дурдан

ярихад гарах ажээ)

тооргонд гарах [tʰɔ:rgɔnd garax],

тооргодох [tʰɔ:rgɔdoχ]

мал хөрөнгө, эд зүйлсийг нь хураан

авч хямдаар худалдах, эсвэл тараах

6. Утга салаалсан үгс:

буриад

хуу [χo:]

бооходой [bɔ:χɔldɔi]

нохойн хошуу [nɔχœ:ŋ χɔʃo:]

хараах [χara:χ]

зугаалах [tsoga:laχ]

халх

бүгд, цөм

чоно

өргөстэй мод

загнах

ярих, хэлэлцэх, нөхөрлөх

7. Золгох, мэндлэх ёс

буриад

ээж чинь сайнавч [e:ʃ ʃʰin sæ:naʃʃʰ]

халх

ээж чинь сайн уу?

Дөчөөд оны үед эрчүүдийг нь бариад явсан, эмэгтэйчүүд нь голцуу үлдсэн байснаас хамгийн түрүүнд асуух үг болжээ.

Мэнд амар [mend amar]

Барийт барийт [bari:tʰ bari:tʰ]

амар сайхан уу?

цай уу.

8. Угсаатны онцлогийг илтгэсэн хэлц :

буриад

Санагын хамгад үйлэнд уран

[sanagi:ŋ hamgad uilend oran]

халх

Санагын бүсгүйчүүд үйлэнд сайн

Түнхэний хөвүүд шарга матахдаа хайн

tʰunxeni: xəwu:d ʃarag matʰaxda: hæ:ŋ]

Түнхэний залуус чарга матахдаа буюу модны үйлэнд сайн

[tʰɔɔ: tɔɣ bæro:laχ]

тогоо торх бариулах

Тогоо торх бариулах

шинэ бэрийн хоол цай,

идээ ундааны

үйлийг хийлгэх, шалгах

хөрөнгийн хөөвөн тогон

сүү гашилгаж бүлээд гаргасан

сэвсийсэн цагаан тос

[xɵrɵŋgi:ŋ xə:wɵŋ tʰɔɔ:ŋ]

хөрөнгийн хөөвөн тогон

9. Буриад дуу

Холбоо нуураа тойрши

[χɔlbɔ: no:ra: tʰœ:rʃi]

Хорин галуу ганганаб

[χɔrin galo: gaŋɣnab]

Хоноон галаа тойрши

[χɔnɔ:ŋ gala: tʰœ:rʃi]

Хатарши байж нааднабди

[χatʰarʃi bæ:ʒ na:dnabdi]

Цэгээн нуураа тойрши

[tʰeɣe:ŋ no:ra: tʰœ:rʃi]

Цэн галуу ганганаб

[tʰeŋ galo: gaŋɣnab]

Цуучил галаа тойрши

[tʰɔʃʰil gala: tʰœ:rʃi]

Хатарши байж нааднабди

[χat^harʃi bæ:ʒ na:dnabdi]

Төхрөөн нуураа тойрши

[t^həxrø:ŋ no:ra: t^hœ:rʃi]

Түмэн галуу ганганаб

[t^humen galu: ɢaŋɢnab]

Түлээ галаа тойрши

[t^hule: gala: t^hœ:rʃi]

Ехэдээ багатай нааднабди

[jexete: baɢat^hæ: na:dnabdi]

Соёл, ахуйд нь шингэсэн буриад үг, хэллэг. Хэдийгээр буриад аялгуугаараа хэлэлцэх нь нэн ховор боловч, хадлан авах, цөцгий цохих, талх барих гэх мэтээр буриад ахуйн соёлоо хадгалахын зэрэгцээ тэндэхийн халхуудад ч заан уламжлуулсан байна. Тиймээс дээрх мэт аж ахуй, соёлын холбогдолтой үйлийн технологид гарч буй үгийн сан буриад аялгууны үг байх нь элбэг.



Зураг 8. Буриад айлын өдөр тутмын ахуй амьдралын орчноос

буриад	утга
завьяа	данх
зөөхий	хольсон тос
ирсэн зочноо хамгийн түрүүнд дайлдаг хүндэтгэлийн зоог	
ёодуу, турба	яндан
лагнун	төмөр хувин
молчий	будаа цайруулах багаж
сээмэг	зуухны арын хэсэг
таг	тавиур, эрэгнэг
хайсаг	авдар
хатаавхаа тарих	алим тарих
хураах	хураах
хорог	шөлний тос
хуниг, хүнэг	модон хувин
цайны талхи	цай үүрүүлэх хэрэгсэл
	модон онгоц дээр төмөр суулгасан цай
	үүрүүлэх багаж. Үүнээс зүйрлээд борцны
	талхи, будааны талхи гэх мэтээр нэрлэжээ.
шайнж	үнээний уургаар хийсэн кеж
шүүршэг	нэг зүйл хөрөө
ямаахай төмс	газрын ургамал, тосонд холж хэрэглэнэ.

Тэдний хэлний бодит статус. «ЮНЕСКО» болон «Этнологийн атлас»-аас монгол хэл, аялгууны байдлыг хураангуйлан хүснэгтэлж харуулбал дараах мэт байна.

Хүснэгт 1. Монгол хэл, аялгууны байдлыг тодорхойлсон нь

Хэл	ISO639-3	Байршил	Ярилцагч	Статус	
				Этнологийн атлас	ЮНЕСКО
Могол (Mogholi)	<u>mhj</u>	Afghanistan	0	9 устсан (Dormant)	4 нэн ховордсон (Critically endangered)
Баоань (Bonan)	<u>peh</u>	China	6,000	7 устахад ойртсон (Shifting)	2 уусаж байгаа (Definitely endangered)
Буриад (China)	<u>bxu</u>	China	65,000	7 устахад ойртсон (Shifting)	-
Дагур (Daur)	<u>dta</u>	China	96,100	7 устахад ойртсон (Shifting)	4 нэн ховордсон (Critically endangered)
Дуншань (Dongxiang)	<u>sce</u>	China	200,000	6b устах аюулд ойртсон (Threatened)	1 аюулд өртсөн (Vulnerable)
Халимаг-Ойрд (Kalmyk-Oirat)	<u>xal</u>	Russian	360,500	6b уусах аюулд ойртсон (Threatened)	2 уусаж байгаа (Definitely endangered)
Буриад (Mongolia)	<u>bxm</u>	Mongolia	45,100	6a бие даасан (Vigorous)	-
Буриад (Russia)	<u>bxr</u>	Russian	219,000	5 хөгжиж байгаа (Developing)	-
Монгол (өвөр м.)	<u>myf</u>	China	3,380,000	2 орон нутгийн шинжтэй (Provincial)	-
Монгол (халх)	<u>khk</u>	Mongolia	2,373,260	1 үндэсний хэмжээний (National)	-

Эндээс харвал, Монгол дахь буриад угсаатны хэлийг буюу Хэнтий, Дорнод, Сэлэнгэ, Хөвсгөлийн буриадыг нийтээр нь багтаагаад *бие даасан* ангилалд оруулсан байна. Тэгвэл, энэхүү өгүүллийн судлагдахуун болох Хөвсгөлийн буриадын хэлний бодит нөхцөл байдалд тулгуурлан ЮНЕСКО-гийн шинжээчдийн хэлний статусыг тодорхойлох 9 төрлийн хүчин зүйлд үндэслэн дүгнэж үзье.

Хүснэгт 2. Хөвсгөлийн буриадын уугуул аялгууны байдлыг тодорхойлох нь

Хэлний статусыг тодорхойлох хүчин зүйлүүд (UNESCO Ad Hoc Expert Group on Endangered Languages, 2003) :	Нэн ховордсон (critically endangered) 1
Дараагийн үеийнхэндээ өвлүүлэх чадамж	0
Ярилцагчийн тоо	0~1
Нийт хүн амын дотор эзлэх хувь	1
Хэрэглээний чадвар	0
Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд оршин тогтнох чадамж	0
Хэлний боловсролд нөлөөлөх чадамж, бичиг үсэг	0
Төрийн болон хэлний байгуулгуудын хандлага, бодлого	0
Тухайн хэлний бүлгийн гишүүдийн өөрсдийн хэлэнд хандах хандлага	0
Баримт бичиг боловсруулах асуудал	0

Бүс нутгийн хүн амын тоонд харьцуулж нийт хүн амын доторх эзлэх хувь гэсэн үзүүлэлтэд л зөвхөн оноо өгч болохоор ажээ. Хэдийгээр нийгмийн зарим өөрчлөлтийг дагаад, тухайлбал хот суурин газар сууж байгаа халхажсан настнууд нас ахих тусмаа төрөлх аялгууныхаа, жишээ нь, буриад угсаатан бол буриад аялгуу нь сэргэж ярьдаг зүйл байдаг ч Хөвсгөлийн буриадудын хувьд хаалттай нийгмийн хүнд хэцүү түүхийн нөлөөгөөр айдаст хэт автсаны учир судалгааны зорилгоо тодорхой танилцуулаад ч зарим дууг дуулахаас татгалзах зэргээр өөрийн хэл аялгуундаа хандах хандлага ч тийм эерэг биш байлаа. Тухайлбал, судалгаанд хамрагдсан нэг настан “1970-аад оны үед цэргээс халагдаж нутагтаа ирээд ганц нэг буриад үг хэлэхэд ээж (эвий)-дээ загнуулсан (хараалгасан)” гэж билээ. Мөн өөр нэг настан “бага байхад цагааны үлдэгдэл гээд алчих байсан юм чинь буриад гэдгээ тас нууж байсан. Халхаараа сурсан юм чинь халх нь сайхан” гэсэн юм. Тиймээс манай нутгийн аялгууны ном, сурах бичигт яагаад Хөвсгөлийн буриадудын үг, хэллэг, хэлний онцлог тохиолдохгүй байна вэ гэдэг тодорхой болж ирж байна. Өмнөх судлаачдыг хээрийн шинжилгээний ангиар очих тэр цаг үед өнөөдрийн байдлаас илүү судлагдахуун байсан нь тодорхой ч түүнийг гарган илэрхийлэх, ярьж, хэлж өгөх боломжгүй байжээ. Эг-Үүр гол даган буриад угсаатан нутаглаж байсан нь маргаангүй учир хэлийг нь судлах боломжгүй ч “буриад аялгуу”-ны ангилалд өнөө хүртэл оруулсаар иржээ. Өөрөөр хэлбэл, буриад нутгийн аялгуугаараа харилцах нь хязгаарлагдмал ч угсаатны ангиллыг

дагуулан хэлний бүлгийг тодорхойлж ангилжээ. Хэлний бодит хэрэглээ нь ахуй соёлын холбогдолтой цөөхөн үгэнд үлдсэн байна. Энд дурдсан зарим үгийг тэдний дурсамжаас л зөвхөн сонсож чадна. Бодитоор хэлний хэрэглээнд үгүй ажээ.



Зураг 9. Нутаг зааж олгосон Цагаан хааны паспорт

Дүгнэлт

Хөвсгөлийн Цагаан-Үүр сумын буриад угсаатны дунд хийсэн хээрийн шинжилгээний үр дүнд тэндэхийн буриад угсаатны хэл нь:

1. Халх аялгуунд ууссан буриад аялгуу юм. Өөрөөр хэлбэл, угсаа гарал нь буриад, хэл нь халх аялгуу болжээ.
2. Халх аялгуунд ууссан учир нөгөө талаас устаж буй хэл аялгуу мөн бөгөөд “Нутгийн аялгууны ангиалал”-д **“Халх аялгууны бүлэг”**-г оруулах нь зүйтэй.

Бичиг үсэг, түүнийг боловсруулсан суурь аялгуу нь хэлэнд нөлөөлдгийн бодит жишээ нь олон нутгийн аялгууны халхажсан түүх мөн билээ. Нөгөө талаас газар зүйн байрлал, нийгэм соёлын орчин зэргээс шалтгаалж түрэг, манж хэлний монголжсон, ойрадажсан хэл аялгуу ч бий⁶. Тэдгээрийг хэл, аялгууны одоо цагийн бодит байдлын үнэлгээ хийж нутгийн аялгууны ангиллыг ч бодитоор дахин нягтлах шаардлага бий.

⁶ Үүнд, тухайлбал, монголжсон түрэг угсааны урианхай нарыг дурдаж болно. Тэд эртнээс Алтай, Тагнын уулаар нутаглаж яваад XVII зууны эцсээр бутарч нэг хэсэг нь Манжид дагаар орж Монгол улсад суурьшсан нь Ховд аймгийн Дуут, Мөнххайрхан сумын урианхай, Баян-Өлгий, Хөвсгөлийн Цагаан нуур сумын урианхайчууд юм. Монголжсон урианхайн хэл зүйн зарим онцлог нь түрэг хэлний үзэгдэл байдаг. Түрэг угсааны монголжсон урианхайчууд тод үсгийг дөрвөд, торгууд, өөлд, захчин нарын адил хэрэглэж байжээ.

Ном зүй

- Austin, K. Peter. (2021). Language Documentation and Language Revitalization. *Revitalizing Endangered Languages*. Edited by Justyna Olko and Julia Sallabank. Cambridge University Press.
- Батзаяа, Г., Батдорж, Ц., Баярчимэг, Э. (2022). Нутгийн аялгуу, *Монгол хэл судлал*. VI. Монгол хэл, аялгуу, үсэг бичиг, авиа судлал (2020), *Монгол хэл судлалын түүх*. I.
- Мөөмөө, С., Мөнх-Амгалан, Ю. (1984). Орчин үеийн монгол хэл, аялгуу, Улаанбаатар.
- Оюунтунгалаг, А. (2004). Монгол Улсын Буриадууд. Урлах эрдэм хэвлэлийн газар.
- Өнөрбаян, Ц., Сарангэрэл, Р., Цэндээ, Ю., Цэрэнчимэд, Л., Батзаяа, Г. (2020). Орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуу, Улаанбаатар.
- UNESCO Atlas of the World's Languages in Danger. <http://unesco.org/languages-atlas/>.
- UNESCO Ad Hoc Expert Group on Endangered Languages (2003). *Language Vitality and Endangerment*. Paris: International Expert Meeting on UNESCO Programme Safeguarding of Endangered Languages.
- Ravindranath, M., & Cohn, A. C. (2014). Can a language with millions of speakers be endangered? *Journal of the Southeast Asian Linguistics Society*, 7, 64-75.
- Svantesson, J. O., Tsendina, A., Karlsson, A., & Franzén, V. (2005). *The Phonology of Mongolian*. Oxford University Press, USA.
- Сумьяабаатар, Б. (1972). Буриадын угийн бичгээс. *Studia Ethnographica*, Том III. Fasc. 2.
- Цолоо, Ж. (2011). Орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуу. Улаанбаатар.
- Elisabetta Ragagnin and Bayarma Khabtagaeva. (2022). Endangered Languages of Northeast Asia. *Languages of Asia*, Volume: 28. Brill. 15-36.
- Janhunen, J. A. (2012). *Mongolian*. Amsterdam; Philadelphia: John Benjamins.

Abstract

Field research of local dialects in Mongolia intensified during 1955-1970s and consequently several works on the classification of local dialects were published. When these works were analyzed, some local dialects were classified into Buryat, Oirat or Khalkha groups based on ethnic origins of the speakers due to lack of sufficient source data. This was undoubtedly a significant result to some extent at that time. However, language evolves in accordance with social, historical and political circumstances. Therefore the Buryat dialect of Khuvsgul was selected as the research subject due its scarce documentation and the need for accurate classification.

As a result of this research, the following conclusions were made. The local dialect of the Buryat ethnic people of Khuvsgul is:

1. a Khalkhized Buryat dialect or a Khalkha dialect with Buryat root
2. is an endangered language as it assimilated to Khalkha dialect and should be considered part of Khalkha dialect group
3. a real-world example of the influence a country's official script and its main dialect has on local dialects. Moreover, depending on their geographical location, there are other dialects that have become Khalkhized and Oiratized. There is a need for contemporary analysis and re-classification of Mongolia's local dialects.

Keywords: classification of Mongolian dialects, Buryat of Khuvsgul, Khalkhized Buryat, language change, endangered language